



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 2 сарын 12 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

“Гэр даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гэр даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгч “Кэй эйч кэй” ХХК-иас өөрийн хувь нийлүүлэгчдэд гаргасан 450,000,000 ширхэг хувьцааны орлого 450,000,000 /дөрвөн зуун тавин сая/ төгрөгөөр, “Гэр даатгал” ХХК-иас хувь нийлүүлэгчдэдээ олгосон ногдол ашиг 300,000,000 /гурван зуун сая/ төгрөгөөр тус тус нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Кэй эйч кэй” ХХК (хуучнаар “Вектор интернэйшнл” ХХК)	2,750,000,000.00	750,000,000.00	3,500,000,000.00	100.0%
	Нийт	2,750,000,000.00	750,000,000.00	3,500,000,000.00	100.0%

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Гэр даатгал” ХХК /ГУЗ-ын дарга П.Золзаяа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000647